

Итгэлийн Тунхаг

- 1. Бид Библийг Ариун Сүнсний онгодоор бичигдсэн, алдаа мадаггүй бөгөөд итгэл болон удирдан чиглүүлэх эрх мэдэл бүхий Бурханы Үг гэдэгт итгэдэг.**

Дэд хууль 4:2; Дуулал 19:7-9; Сургаалт үгс 30:5-6; 1Коринт 2:13; Галат 1:8-9; 2Тимот 3:15-17; 2 Петр 1:20-21; Илчлэлт 22:18-19

- 2. Бид Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурвалаар мөнхөд оршдог цорын ганц Бурхан байдаг гэдэгт итгэдэг.**

Эхлэл 1:1-3; Исаиа 44:6-8; Матай 28:19-20; Марк 12:29; Иохан 1:1-4; Үйлс 5:3-4; 2Коринт 13:14

- 3. Бид Бурхан Эцэг бол хэмжээлшгүй хүч чадалтай, хувь хүн бүхий сүнс бөгөөд хайр, хүч, мэргэн ухаан, ариун байдалд төгс нэгэн гэдэгт итгэдэг. Тэрээр хүн бүрийн асуудалд энэрэнгүй ханддаг бөгөөд залбирлыг сонсоод хариулдаг, мөн Есүс Христээр дамжин Өөр дээр нь ирсэн хүн бүрийг нүгэл болон үхлээс авардаг гэдэгт итгэдэг.**

Эхлэл 21:23; Гэтлэл 33:14; 2Самуел 24:14; Исаиа 40:28; Иеремиа 31:3, 32:17; Иохан 4:24; Ром 5:8, 11:33-34; Ефес 1:19-20; 1Иохан 5:14-15; Илчлэлт 4:8

- 4. Бид Бурханы Хүү бол Аврагч Есүс Христ бөгөөд Бурханы цорын ганц хайртай Хүү гэдэгт болон Түүний бурханлаг байдал, онгон эмэгтэйгээс төрсөнд нь, Түүний гэмгүй амьдралд нь, гайхамшгуудад нь хийгээд Түүний урсан цусаар ирсэн авралын үхэлд нь итгэдэг. Мөн Түүний дахин амилалт болон Эцгийнхээ баруун гарын суудал руу дээш одсонд нь, Өөрийн хүмүүсийн төлөө үргэлжлүүлэн зуучлан залбирч байгаад нь болон хүч ба яруу алдар дотор өөрийн биеэр дахин ирнэ гэдэгт бид итгэдэг.**

Матай 24:30; Марк 8:38; Лук 1:34-35, 24:27; Иохан 1:1-2, 14, 18, 3:16; Ром 3:23-26, 8:34; 1Коринт 15:3-4; Еврей 4:15

- 5. Бид Бурханы Ариун Сүнс бол Туслагч болон Тайвшруулагч гэдэгт, мөн Түүний өдөр бүрийн зааварчилгаа хийгээд үнэний илчлэлтэнд итгэдэг. Түүнчлэн нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаарх Түүний илчлэлтэд, авралын хором бүрд Өөрийн оршихуйгаараа байдаг болон итгэгчдийг бурханлаг амьдралаар амьдрах боломжтой болгодог гэдэгт бид итгэдэг.**

Иохан 3:5-8, 14:16-17, 16:13-14; Үйлс 1:8; 1Коринт 12:13; Ефес 4:30-32, 5:18

- 6. Хүн бүр төрөлхийн нүгэлт чанартай төрж Бурханаас тусгаарлагддаг бөгөөд аврал зайлшгүй хэрэгтэй гэдэгт бид итгэдэг. Есүс Христийг Аврагч Эзэн хэмээн хүлээн авснаар дамжуулан ирдэг авралд Ариун Сүнсний дахин төрөлт нь үнэхээр чухал гэдэгт бид итгэдэг.**

Иохан 3:5-8, 5:24; Үйлс 2:21; Ефес 1:6-7, 2:8-9; Тит 3:5; 1Петр 1:23

- 7. Бид аврагдсан болон төөрсөн хүн бүр дахин амилна гэдэгт, мөн аврагдсан хүмүүс мөнхийн амьдралд харин төөрөгсөд тамд очих болно гэдэгт итгэдэг.**

Лук 16:19-26; 2Коринт 5:8; Филиппой 1:23; 2Тесалоник 1:7-9; Илчлэлт 20:11-15

- 8. Бидний Эзэн Есүс Христийн дотор итгэгчдийн сүнслэг нэгдмэл байдал байдаг гэдэгт бид итгэдэг.**

Үйлс 2:42-47; Ром 15:5-6; 1 Коринт 12:12-13; Ефес 4:3-6